

ZMĚNA U PODÁNÍ ŽÁDOSTI O TRVALÝ POBYT

2021.9.1 -ний өдрөөс БН Чех Улсад Байнга оршин суух зөвшөөрлийн өргөдөл гаргахын тулд 2021.9.1 -ний өдрөөс чех хэлний шалгалтыг А2 түвшинд өгөх тушаал гарсан

Өөрлөлт гарах болсон шалтгаан

БН Чех Улсын зүгээс гадаад иргэдээс шаардах чех хэлний мэдлэгийн түвшинг Европын Холбооны орнуудын хэмжээнд харьцуулж үзэхэд хамгийн доогуур түвшинд байсан. БН Чех Улсын шилжилт хөдөлгөөний стратеги бодлогын хүрээнд гадаад иргэдийн чех хэлний мэдлэг А1 түвшинд байх нь бие дааж харилцахад хангалтгүй гэж тодорхойлсон байдаг.

Чех хэлний мэдлэг **А2 түвшинд** байх тохиолдолд гадаадын иргэд нь өдөр тутмын амьдралын хүрээнд шаардлагатай бүх мэдээллийг илүү сайн ойлгож, чөлөөтэй харилцах чадвартай болох юм.

Хэзээнээс эхэлж А2 түвшинд шалгалт авч эхлэх вэ?

Байнга оршин суух зөвшөөрлийн өргөдлийг **9 сарын 1-ний өдрөөс хойш** гаргах гадаадын бүх иргэд чех хэлний шалгалтыг **А2 түвшинд** өгнө.

А1 түвшингийн шалгалтыг хэдий хүртэл авах вэ?

2021 оны 8-р сарыг дуустал хугацаанд Байнга оршин суух зөвшөөрлийн өргөдөл гаргах гадаадын иргэд **А1 түвшингийн чех хэлний шалгалт өгсөн гэрчилгээг өгнө.**

Ямар дэмжлэг авч болох вэ?

Гадаадын иргэд нь Гадаад иргэдийн интеграцчилалыг дэмжих төвүүдээс болон бусад Төрийн бус байгууллагуудын зохион байгуулж байгаа чех хэлний дамжаанд явж суралцах боломжтой.

Шалгалтанд хэрхэн бэлтгэх талаархи арга зүйн зааврыг доорхи хаягуудаар орж танилцана уу:

- www.zkouskaA2.cz
- [Facebook](#) - @cestinaprotrvalypobyt,
- YouTube – Zkouška z češtiny pro trvalý pobyt.

Эдгээрээс гадна хэлний сургалт явуулдаг бусад сургуулиудын төлбөртэй чех хэлний дамжаанд суралцаж болно.

Шалгалт өгөхөд ямар төлбөртэй вэ?

Шалгалтын үнэ 2500 крон. **Чех хэлний анхны шалгалтын** төлбөрийн эрхийн бичгийг Дотоод Хэргийн Яамны Цагаачлал ба шилжилт хөдөлгөөний бодлогын газраас олгоно.

МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР:

<https://www.mvcr.cz/clanek/obcane-tretich-zemi-trvaly-pobyt.aspx?q=Y2hudW09Mg%3d%3d>